

БАТЛАВ
 ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХӨТ БАЙГУУЛАЛТЫН
 ГАЗРЫН ДАРГА Д.ЦОЛМОН



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨРИЙГ
 ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.03.28

Орхон аймаг

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хариуцах албан тушаалтан
1	1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1 Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн болон өөрийн байгууллагаас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контент, сурталчилгааны материалуудыг байгууллагын албан ёсны цахим хуудас, сошиал сувгууд, дотоод сүлжээ, хэвлэл мэдээллийг хэрэгсэл, мэдээллийн салбар, лед дэлгэц, бусад хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх.	Жилийн турш	-Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх	-Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн -Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
2		1.2 Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	Жилийн турш	-Иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	-Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
3		1.3 Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн арга хэмжээнд хамруулах, зохион байгуулах	Жилийн турш	-Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх -Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, самбар зэрэг бүхий л боломжит хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх	-Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

4		1.4 Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор авлигын талаар мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар сурталчлах	Жилийн турш	-Сурталчилгааг бүх арга хэлбэр, мэдээллийн сувгаар хүргэсэн байх	Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн
5		1.5 Төрийн албанд шинээр томилогдсон болон бусад төрийн албан хаагчдад зориулсан авлигын эсрэг сургалтыг зохион байгуулах	Жилийн турш	-Шинээр томилогдсон албан хаагчдыг сургалтад бүрэн хамруулсан байх	Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
6	2.Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	2.1 Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангаж, саналыг тусгах, хэрэгжилтийн талаарх мэдээллийг нээлттэй, ил тод мэдээлэх	Жилийн турш	-2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх	Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
7					
8		2.2 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, нээлттэй мэдээллийг ил тод байршуулж мэдээлэх, хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж олон нийтэд ил тод мэдээлэх	Жилийн турш	-Цахим хуудаст хуульд заасан нээлттэй мэдээллийг байршуулах -Хуульд заасан нээлттэй мэдээллийг шинэчилсэн байх	Ерөнхий нягтлан бодогч, Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн
9	3.Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	3.1 Олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах	Жилийн турш	-Цахим үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлах	Газрын удирдлагын хэлтсийн дарга, Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга
10		3.2 Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлог тохируулан авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх	Жилийн турш	Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээний онцлогт тохируулан зохион байгуулах -Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх	Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
11		3.3 Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах	Жилийн турш	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, үйл явцыг ил тод мэдээлэх	Ерөнхий нягтлан бодогч

12		3.4 “Товш” аппллейшнийг сурталчлах, санал өгөх ажлыг зохион байгуулах	Жилийн турш	Товш аппликейшнийг сурталчлах ажлыг зохион байгуулсан байх	Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн
----	--	---	-------------	--	--

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *О.Дүрэнжаргал*

О.ДҮҮРЭНЖАРГАЛ

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭН ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2025.12.01

Орхон аймаг

д/д	Зорилт	Арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хариуцах албан тушаалтан
1	1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1 Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн болон өөрийн байгууллагаас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контент, сурталчилгааны материалуудыг байгууллагын албан ёсны цахим хуудас, сошиал сувгууд, дотоод сүлжээ, хэвлэл мэдээллийг хэрэгсэл, мэдээллийн салбар, лед дэлгэц, бусад хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх.	Жилийн турш	-Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх	Авлигатай тэмцэх газраас гаргасан албан ёсны зурагт хуудас, 4 төрлийн тараах материалыг байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан. Мөн Олон нийтийн цахим сүлжээ facebook.com, erdenetgazar цахим хуудсаар "Авлигын эсрэг нэгдье", "Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа" зэрэг зурагт хуудас постер, богино хэмжээний шторкуудыг байршуулсан. Аймгийн Хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан "Авлигын эсрэг хамтдаа-2025" дэвжээ тэмцээнд байгууллагын 7 албан хаагч 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр оролцохоор бэлтгэл ажил хангагдсан. Тус тэмцээний хүрээнд Авлигын эсрэг 3 минут 46 секунд рийл бичлэг хийж аймгийн Хууль эрх зүйн хэлтсийн файс хаягт байршуулсан бөгөөд 194 лайк, 28 коммент, 108 шэйртэй болсон байна.
2		1.2 Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	Жилийн турш	-Иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/25 тушаалаар 2025 оныг "Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил" болгон зарласантай холбогдуулан Газрын харилцааны ажилтны өдрийг салбарын хэмжээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд манай байгууллагаас ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 5, 6-р ангийн сурагчдын дунд "Ирээдүйн Эрдэнэт хот" гар зургийн уралдааныг 2025 оны 05 дугаар сарын 29-ний

					өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдрийн хооронд зохион байгуулан ажилласан. Гар зургийн уралдаанд хүүхдүүд идэвхтэй оролцож нийт 139 хүүхэд бүтээлээ ирүүлсэн. Ирсэн бүтээлүүдийг ангилж үзвэл Ухаалаг Эрдэнэт, Ногоон Эрдэнэт, Бүх хүнд ээлтэй хот, одоогийн Эрдэнэт-Ирээдүйн Эрдэнэт гэсэн сэдвүүдээр зурагдсан байлаа. Энэхүү уралдааныг "Мэйнспринг" ХХК-ийн Найрамдал хотхон төсөл ивээн тэтгэж нийт 7 хүүхдийн бүтээлийг шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулсан. Мөн Нээлттэй хаалганы өдөрлөгийн хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Булаг багт, 04 дүгээр сарын 29-ний өдөр Баянбулаг багт, 05 дугаар сарын 22-ны өдөр А.Амарын талбайд, 2025 оны 09 дүгээр сарын 10-18-ны өдрийн хооронд гэр хорооллын 17 багт тус тус зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем буюу газрын харилцааны e-gaza цахим систем, газрын биржийн mle цахим систем байгууллагын үйл ажиллагааны талаар 630 орчим иргэнд танилцуулга, мэдээлэл, зөвлөгөө, өгч, 250 гаруй брошюр тарааж, "Иргэдийн оролцоо-төлөөлөгчийн манлайлал-төрийн үйлчилгээ" нэгдсэн өдөрлөгийн арга хэмжээ 2025 оны 11 дүгээр сарын 20-ноос 12 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээний хүрээнд нийт 60 гаруй иргэдэд газрын харилцааны салбарын үйл ажиллагаа, цахим ситем, хот байгуулалтын цахим системийн талаар мэдээлэл зөвлөгөө ажилласан.
--	--	--	--	--	--

3		1.3 Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн арга хэмжээнд хамруулах, зохион байгуулах	Жилийн турш	-Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх -Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, самбар зэрэг бүхий л боломжит хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх	Байгууллагын албан ёсны erdenet.gazar.gov.mn цахим сайтад Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчлан байршуулсан.
4		1.4 Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор авлигын талаар мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар сурталчлах	Жилийн турш	-Сурталчилгааг бүх арга хэлбэр, мэдээллийн сувгаар хүргэсэн байх	Байгууллагын албан ёсны erdenet.gazar.gov.mn цахим сайтад авлигын эсрэг бүхий л төрлийн сурталчилгааг байршуулан иргэд олон нийтэд хүргэж байна.
5		1.5 Төрийн албанд шинээр томилогдсон болон бусад төрийн албан хаагчдад зориулсан авлигын эсрэг сургалтыг зохион байгуулах	Жилийн турш	-Шинээр томилогдсон албан хаагчдыг сургалтад бүрэн хамруулсан байх	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан шинэчилсэн журмаар гарах ХАСХОМ-н сургалтад улсын ахлах байцаагч, 3 хяналтын улсын байцаагч улсын байцаагч нарыг хамруулсан.
6	2.Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал чирэгдлийг бууруулах, олон	2.1 Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд	Жилийн турш	-2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 12 ажлын цахилгаан хуваарилах байгууламж РП- 4ш, ТП- 1ш, 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 2

	нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	иргэдийн оролцоог хангаж, саналыг тусгах, хэрэгжилтийн талаарх мэдээллийг нээлттэй, ил тод мэдээлэх		хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх	байршилд, цэвэр усны шугам- 4.3км, дулааны шугам- 1.1км, ариутгах татуургын шугам- 75м, техникийн нөөц усны шугам- 5.1 км болон УДДТ-ын барилга 1ш байгууламжийг тус тус хот байгуулалтын цахим систем болох urban.gov.mn оруулсан.
8		2.2 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, нээлттэй мэдээллийг ил тод байршуулж мэдээлэх, хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж олон нийтэд ил тод мэдээлэх	Жилийн турш	-Цахим хуудаст хуульд заасан нээлттэй мэдээллийг байршуулах -Хуульд заасан нээлттэй мэдээллийг шинэчилсэн байх	Байгууллагын www.erdenet.gazar.gov.mn цахим хуудсанд 71 мэдээ мэдээлэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт зэрэг 47 мэдээллийг хариуцсан албан хаагчтай хамтран оруулсан . Нийтийн мэдээллийг ил тод байдлын хуулийн дагуу байгууллагын холбогдох 65 мэдээллийг www.shilen.gov.mn цахим хуудсанд оруулж 94.7% үнэлэгдсэн байна.
9	3.Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	3.1 Олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах	Жилийн турш	-Цахим үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлах	-Газрын удирдлагын нэгдсэн сангийн www.egazar.gov.mn сайт, -Байгууллагын www.erdenet.gazar.mn сайт -Газрын биржийн цахим систем www.mle.mn сайт -“Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар” фейсбүүк хуудас -Монгол Улсын Засгийн газрын төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудсаар байгууллагатай холбоотой байгууллагын төлөвлөгөө, тайлан, мэдээ, мэдээлэл, ил тод байдлын мэдээлэл гэх мэт бүх төрлийн үйл ажиллагааг сурталчилан ажиллаж байна. Мөн 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Булаг багт, 04 дүгээр сарын 29-ний өдөр Баянбулаг багт, 05 дугаар сарын 22-ны өдөр А.Амарын талбайд, 2025 оны 09 дүгээр сарын 10-18-ны өдрийн хооронд гэр хорооллын багт,

					2025 оны 11 дүгээр сарын 20-ноос 12 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл нийт 27 багт нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээний хүрээнд нийт 700 гаруй иргэдэд газрын харилцааны салбарын үйл ажиллагаа, цахим ситем, хот байгуулалтын цахим системийн талаар сурталчилан ажилсан.
10		3.2 Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлог тохируулан авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх	Жилийн турш	Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээний онцлогт тохируулан зохион байгуулах -Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх	Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран “Ажлын байрны ёс зүй сургалтыг 2025 оны 05 сарын 16-нд зохион байгуулан байгууллагын 18 албан хаагчийг хамруулсан. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 3 төрлийн зөвлөмжийн биелэлтийг гарган ГЗБГЗЗЕГ-т 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 406 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
11		3.3 Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах	Жилийн турш	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, үйл явцыг ил тод мэдээлэх	2025 онд худалдан авах ажиллагаа зарлагдаагүй.

ТАЙЛАН ГАРГАСАН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

[Signature]

О. ДҮҮРЭНЖАРГАЛ

ХЯНАСАН: ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР

ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

[Signature]

РГАЛБААТАР

